



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 26

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэхь заалт, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар"-ын дарга Х.Оюун-Эрдэнэд зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /Г.Оргилмөрөн/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2019.04.30

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 26 тоот тушаалын хавсралт

"Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн" гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

/ сая.төгрөгөөр/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
07/75	Шатахууныг захиран зарцуулахдаа хяналтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй.	ЦНБГ	Дарга, нягтлан бодогч	Х.Оюун-Эрдэнэ, Б.Наранцэцэг		19.57
08/76	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж буй орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллага байтал хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг 57.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр аймгийн засаг даргатай БЗА-216/17 тоот гэрээг 2017 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээний дүн 57.4 сая төгрөг нь шууд материалын зардал бөгөөд түүнд нэмэгдсэн өртгийн албан татварын 5.2 сая төгрөгийг оруулж тооцсон.	СТСХ	Дарга, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	Н.Бямбацэцэг, М.Алтангэрэл		5.2
	Нийт дүн					24.77



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**“Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2017 оны санхүүгийн үйл
ажиллагааны үр дүн”**



**Дотоод хяналт алдагдсанаас хөрөнгийн ашиглалт хангалтгүй, төсвийн
төсөөллийг зорилтот төвшинд арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар
бодитой төлөвлөөгүй байна**

**Орхон аймаг
2018 он**

АГУУЛГА

Аудитын тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга: Ц.Нармандах	Бүлэг 1 Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул, байгууллагын дүрэмд заасан зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Аймгийн Засаг дарга, байгууллагын даргын хооронд байгуулсан гэрээ бодитой дүгнэгдээгүй байна.	6
Аудитын менежер: Б.Эрдэнэ	1.1 ЦНБГ-ыг чиг үүрэг төстэй бусад байгууллагатай нэгтгэх, эсвэл өөрийгөө санхүүжүүлэх боломжийг судлалгүй орон нутгийн төсвөөс жил бүр санхүүжүүлсэн хэвээр байна.	6
Аудитор: Г.Оргилмөрөн	1.2 Байгууллагын дарга, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ бодитой дүгнэгдээгүй байна.	7
Т.Болормаа Б.Буян-Ундрах	1.3 Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.	7
2018 оны 07 дугаар сар	Бүлэг 2: Төсвийн төслийг зорилтот төвшинд тооцоо судалгаатай, үндэслэлтэй боловсруулж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчимд нийцүүлэн, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах шаардлагатай байна.	8
	2.1 Бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэлгүй аль болох үйл ажиллагааны зардал, орон тоог нэмэгдүүлэх гэсэн хүрэх үр дүн нь тодорхой бус үндэслэлгүй төсөв боловсруулдаг ч батлагдсан төсөв нь өөрчлөлтгүй байна.	8
Уг тайланг Орхон аймаг дахь Төрийн Аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү.	2.2 Зардлын гүйцэтгэлийн 90.53 хувийг цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ болон тогтмол зардал эзэлж байна.	9
	2.3 Шатахууны төлбөрт оны эцэст илүү төлбөр шилжүүлснээр авлага үүсгэсэн, төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.	11
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, лавлах зүйл байвал	Бүлэг3: Үндсэн хөрөнгөд тавих хяналт хангалтгүйгээс хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй, үр дүн гараагүй байна.	12
	3.1 Тус байгууллага нь 77.3 сая төгрөгийн ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн нь холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна.	12
Дугаарын утас: 70357955 дугаарын факсаар харилцана уу.	3.2 Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь үйл ажиллагаа явуулаад удаагүй боловч орон нутгийн санхүүжилтээр авсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй, бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.	15
Хаяг: Орхон аймаг дахь төрийн Аудитын газар	3.3 Шилэн дансны хуулийн дагуу мэдээлэлээ байршуулдаг боловч зарим мэдээлэлийг буруу, дутуу байршуулсан байна.	18
Баян-өндөр сум, Хүрэнбулаг баг,	Дүгнэлт	19
	Зөвлөмж	19
Нутгийн удирдлагын ордон	Алдаа зөрчлийн нэгтгэл	20
	Холбогдох байгууллагын санал	21
	Тайлан баталгаажуулах тушаал	24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЦНБГ	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар
ЦНБ	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

1. **Аудит хийх үндэслэл:** Монгол улсын ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.
2. **Аудитын зорилт:** Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
 - Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагаа холбогдох хууль, эрх зүйн хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
 - Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын төсвийн зардлын зарцуулалт арвилан хэмнэлттэй, үр ашигтай байгаа эсэх
 - Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хамгаалалт үр дүнтэй байгаа эсэх
3. **Аудитын хамрах хүрээ:** Аудитаар аймгийн ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар, Хот тохижуулах газар, Санхүү төрийн сангийн хэлтэс зэргийг хамруулан аудит хийлээ.
4. **Аудитын арга зүй:** Аудитыг гүйцэтгэхдээ ТХШС, удирдамж (АДБОУС 3000-3100) гүйцэтгэлийн аудитын журмын хүрээнд аймгийн ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар, Хот тохижуулах газар болон бусад холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа тодруулга авах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллаа.
5. **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:** Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйл, холбогдох тайлан, мэдээ, судалгааг, аудитын ажлын баримтад хавсаргав. Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:
 - Төрийн аудитын тухай хууль
 - Төсвийн тухай хууль
 - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - ТБОНӨХБАҮХАТХууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
 - Хөдөлмөрийн тухай хууль
 - Шилэн дансны тухай хууль
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
 - Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газар, аймаг сумын ИТХ-ын тогтоол,
6. **Аудит хийх бүрэлдэхүүн:** Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ

чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Оргилмөрөн, Б.Буян-Ундрах, Т.Болормаа нар гүйцэтгэлээ.

- 7. Аудитын тайлан, баталгаажуулалт:** Аудитыг 2018 оны 6 сарын 08-ны өдрөөс 7 дугаар сарын 06-ны хооронд хийж гүйцэтгэн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь Орхон аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор ОНӨААТҮГ болон байгуулагдсан. Харин аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 45 дугаар тогтоолоор төрийн байгууллага УТҮГ болж өөрчлөгдсөн байна.

Тус байгууллага нь хотын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэн аж ахуйн нэгж байгууллагад арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар 614.2 сая төгрөгийн ногоон байгууламж, 185.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 96.6 сая төгрөгийн бараа материал бүхий хөрөнгө тус тус бүртгэгдсэн байна.

Орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 213.5 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө бусад хөрөнгө оруулалтын зардлаас 96.6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бүлэг 1: Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул, байгууллагын дүрэмд заасан зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Аймгийн Засаг дарга, байгууллагын даргын хооронд байгуулсан гэрээ бодитой дүгнэгдээгүй байна.

1.1 ЦНБГ-ыг чиг үүрэг төстэй бусад байгууллагатай нэгтгэх, эсвэл өөрийгөө санхүүжүүлэх боломжийг судлалгүй орон нутгийн төсвөөс жил бүр санхүүжүүлсэн хэвээр байна.

Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 149 дугаар тогтоолоор Орхон аймагт цэцэрлэгжүүлэлтийн ажлыг мэргэжлийн түвшинд хийж чанаржуулах, арчлалт хамгаалалтыг сайжруулах, ажлын чанар түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын дэргэд 100 хувь орон нутгийн өмчит “Цэцэрлэгжүүлэлт-Ногоон байгууламж” ОНӨҮГ-ыг байгуулах шийдвэр гаргаж, 2014 оны 01 сарын 11-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлэн “Орхон аймгийн цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдсан байна.

ЦНБГ нь ТБОНӨТХ-ийн 15.2 дахь заалтын дагуу өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдаж, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах ёстой хэдий ч 2014 онд 100 хувь орон нутгийн төсвөөс санхүүжилт авч, үйл ажиллагаагаа явуулсан байна.

Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж” ААТҮГ-ын ангиллыг өөрчилж “Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар” УТҮГ болгосон байна. Монгол улсын засгийн газрын 2014 оны 05 сарын 10-ны өдрийн 147-р тогтоолын 2.2-т “төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх замаар төсвөөс олгох татаасыг үе шаттайгаар бууруулах, төсвөөс гаргах”, 2.3-т “ яамд, төрийн захиргааны болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах хоол хүнсний хангамж, цэвэрлэгээ, засвар, харуул хамгаалалт зэрэг нийтлэг үйлчилгээ үзүүлэх газруудыг нэгтгэх, зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх” гэж заасан.

ЦНБГ-ыг чиг үүрэг төстэй бусад байгууллагатай нэгтгэх, эсвэл өөрийгөө санхүүжүүлэх боломжийг хангаж ААТҮГ хэвээр үлдээж, орон нутгийн төсвийг хэмнэх байтал дээрх засгийн газрын тогтоолыг зөрчиж, эсрэгээр нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон жил бүр урсгал зардалд 213.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Иймд тус байгууллагыг цэцэг, ургамал үрслүүлэх, мод үржүүлэх замаар аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажилладаг ААТҮГ-ийн хэлбэрт шилжүүлэх боломжийг судлах шаардлагатай байна.

Тус газар нь 2017 онд “хотын ногоон байгууламжийн тухай ойлголт, түүний ач холбогдол, тавигдах шаардлага, түүнд мөрдөгдөх стандарт” сэдвээр аймгийн Насан туршийн боловсрол олгох төвтэй хамтран Наран, Цагаан чулуут, Рашаант, Шанд, Яргуйт, Их залуу багуудын иргэд болон 15-р цэцэрлэгийн багш ажилчид нийт 69 иргэнд сургалт зохион байгуулснаас өөр ямар нэгэн сургалт зохион байгуулаагүй байгаа нь Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын

дүрмийн 4.2.7 “Ногоон байгууламжийн чиглэлээр сургалт зохион байгуулах”, 4.2.9 “ Иргэд, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх,” гэсэн заалтуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Иймд Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын дүрэмд заасны дагуу иргэд, аж ахуйн нэгжүүдэд ногоон байгууламжийн чиглэлээр сургалтыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

1.2 Байгууллагын дарга, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээ бодитой дүгнэгдээгүй байна.

2017 оны Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээг Нэг талаас Орхон аймгийн Засаг дарга, нөгөө талаас “Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар” ТБАГУТҮГ газрын дарга нарын хооронд байгуулах байтал нэг талаас Орхон аймгийн Засаг дарга, нөгөө талаас “Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан байна.

Тухайлбал: Гэрээний 2.5-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн ТУЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, үр ашгийг дээшлүүлэх зорилтод түвшинг гэрээний хавсралтаар батална.”, 3.3-т “Захирал нь газрын “Зорилтын санал”-ын талаар аймгийн засаг даргатай тохиролцох бөгөөд түүнд үндэслэн гаргасан тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг гэрээний хавсралтанд тусгасан үзүүлэлтүүдээр биелүүлэн газрын ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүргийг хүлээнэ.” 3.3-т “ Захирал нь 3 дугаар сарын 15-ны дотор газрын жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргуулж, тайланг аудитын дүгнэлтийн хамт аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.” гэж заасан байна.

Тус газрын дарга гэрээнд тусгагдсан гүйцэтгэх захирлын үүргийн зүйл заалт бүрээр биелэлтээ гаргаж, Засаг даргаар 94 хувьтай, ОНӨГ-аар 80 хувьтай дүгнэгдсэн байна.

Уг гэрээг дүгнэхдээ үзүүлэлт тус бүр дээр оноо тавилгүй нийт дүн дээр нь дүгнэсэн байна.

Гэрээний 3.3 дахь заалтын биелэлтийг “ 2017 оны байдлаар үйлдвэрийн ашиг орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг аймгийн Засаг даргатай тохиролцож явуулаагүй бөгөөд цаашид энэ чиглэлийн арга хэмжээ явуулах хэтийн зорилт бий” гэж гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.” заасныг зөрчсөн гэрээ байгуулан түүнийгээ бодитой дүгнэдэггүй болох нь харагдаж байна.

Иймд Засаг даргатай байгуулсан гэрээг үзүүлэлт бүрээр бодитой дүгнэж байх шаардлагатай байна.

1.3 Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Газрын даргын 2016 оны 11 сарын 23-ны өдрийн А/34 дугаар тушаалаар дотоод хяналтын комиссын даргаар техникчийг, гишүүнээр 1 цэцэрлэгжүүлэгчийг томилсон байна.

Дотоод хяналтын комисс нь 2017 оны төлөвлөгөөндөө дараах ажлуудыг зохион байгуулахаар тусгасан байна.

1. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт болон нутгийн удирдлагын шийдвэрийг дагаж мөрдөх.

2. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, хөдөлмөрийн гэрээ түүний биелэлт
3. Өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа
4. Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагын хэрэгжилтийн явц
5. Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангах, төсвийн зарцуулалтын шалгуур үзүүлэлтийг хэрхэн ханган гүйцэтгэж байгааг хянах
6. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг ханган ажиллаж байгаа байдал
7. Хотын ногоон байгууламжийн мод, бут, сөөг тарих, түүнийг арчлах, ургуулах, хамгаалах, ногоон байгууламжид хийгдэх бусад арчилгаа тордолтын ажлыг хянах .

Дээрхи дотоод хяналт шалгалтын хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн ажлуудаас хийж гүйцэтгэсэн ажил хангалтгүй, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд тус байгууллагын удирдлага өдөр тутмын үйл ажиллагаандаа дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 2 : Төсвийн төслийг зорилтот төвшинд тооцоо судалгаатай, үндэслэлтэй боловсруулж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчимд нийцүүлэн, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах шаардлагатай байна.

2.1 Бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүй аль болох үйл ажиллагааны зардал, орон тоог нэмэгдүүлэх гэсэн хүрэх үр дүн нь тодорхой бус үндэслэлгүй төсөв боловсруулдаг ч батлагдсан төсөв нь өөрчлөлтгүй байна.

Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газарт 2016, 2017 онд жилийн 213.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, эрдэнэт сангаас санхүүжиж үйл ажиллагаа явуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 02-ны өдрийн 149-р тогтоолын хавсралтаар бүтэц, орон тоог нийт 22 хүнээр тогтоосон ба өөрчлөлт ороогүй байна.

Үүнд: Дарга -1, мэргэжилтэн -1, нягтлан бодогч-1, нярав-бичиг хэрэг-1, цэцэрлэгчин -15, техникч-жолооч-1, жолооч-1, сахиул-1.

Жилийн төсөв батлагдсаны дараа сар, улирлын төсвийн хуваарийг байгууллагын саналыг үндэслэн боловсруулдаг байна.

Тус байгууллагыг анх байгуулахаас эхлээд аймаг, орон нутгийн зүгээс хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч төсөв, хөрөнгө зарцуулж иржээ.

2017 онд гэхэд аймгийн Засаг даргын санаачлагаар нийтийн эзэмшлийн зам талбайн төмөр хайсыг ургамлан хашлага, амьд хашаа хийх төсөл арга хэмжээний хүрээнд 171.9 сая төгрөгөөр 60,633 ширхэг шар хуайс, 738 ширхэг хайлаас нийлүүлснийг тус байгууллага 19 байршилд шилжүүлэн суулгаж Байгаль орчны газраас арчилгааны зардалд 20.0 сая төгрөгийг авч зарцуулсан болон Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд 51.7 сая төгрөг, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээнд 19.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Ногоон байгууламжийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа тул түүнд хийгдэх арчилгаа тордолтын зардал болон орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа гэж тайлбарлаж буй боловч 1 хүнд ногдох стандарт норм, талбайг тогтоосон баримт бичиг байхгүй, тухайн

байгууллагын зүгээс сар, улирлын байдлаар ажлын ачаалал орон тооны хүрэлцээг тодорхойлж тогтоосон судалгаа тооцоолол байхгүй, эрх бүхий байгууллагад энэ талаар албан ёсоор санал санаачлага хүргүүлж байгаагүй байна. Өөрөөр хэлбэл 2017 онд хотын ногоон байгууламжийн хамгаалалтын төмөр хайс хашлагыг амьд хашлага буюу ургамлан хашлагаар солих ажлыг гүйцэтгэх хүрээнд ажлын ачаалалтай ажилласан байх боловч зөвхөн ногоон байгууламжийн арчилгаа тордолт зэрэг бусад зорилтот байнгын үйл ажиллагааны хүрээнд орон тоо, ажлын ачааллыг тогтоосон судалгаа, тооцоолол байхгүй байна.

Гэтэл Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар нь 2016 оны төсвийн төслөө 518.08 сая төгрөгөөр, 2017 оны төсвийн төслөө 476.94 сая төгрөгөөр, нийт 29 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар боловсруулсан байна. Мөн гадаад томилолтын зардалд 6.0 сая төгрөг төсөвлөсөн зэргээр үйл ажиллагааны бүхий л зардлыг аль болох өндөр дүнгээр боловсруулдаг байна.

Дээрхээс үзэхэд тус байгууллага нь төсөв боловсруулахдаа бодитой тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл, хүндрэл бэрхшээл, чиг үүрэг, төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв боловсруулдаггүй, төсвийг аль болох нэмэгдүүлж үйл ажиллагааны зардлаа батлуулах гэсэн хэт өндөр төсвийн төсөл боловсруулдаг байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийн 90.53 хувийг цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ болон тогтмол зардал эзэлж байна.

Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газрын 2017 оны үйл ажиллагааны зардалд 213.5 сая төгрөг батлагдаж санхүүжилтийг бүрэн хүлээн авч гүйцэтгэлээр 211.6 сая төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 1.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ОНХО-аас 71.6 сая төгрөг, БОАЖГ-аас 20.0 сая төгрөг, эрдэнэт сангаас 5.0 сая төгрөг /баяр наадмын үйл ажиллагаатай холбоотой/ нийт 96.58 сая төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр 95.51 сая төгрөг зарцуулж, 0.07 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл: /сая.төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт /-хэтрэлт	Дүнд эзлэх хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	213.50	211.63	1.87	100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	213.50	211.63	1.87	100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212.61	210.74	1.87	99.58
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168.24	167.13	1.11	78.97
Үндсэн цалин	122.10	127.83	-5.74	60.40
Нэмэгдэл	29.51	24.60	4.91	11.62
Унаа хоолны хөнгөлөлт	16.63	14.70	1.93	6.95
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18.51	18.30	0.20	8.65
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6.15	6.15	0.00	2.91
Хангамж, бараа материалын зардал	6.25	6.25	0.00	2.95
Бичиг хэрэг	1.01	1.37	-0.36	0.65
Тээвэр, шатахуун	3.73	3.73	0.00	1.76
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.10	0.89	0.21	0.42
Ном, хэвлэл	0.10	0.10	0.00	0.05

Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.07	0.06	0.01	0.03
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.25	0.10	0.15	0.05
Нормативт зардал	2.92	2.92	0.00	1.38
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.92	2.92	0.00	1.38
Эд хогшил, урсгал засварын зардал	2.14	2.12	0.02	1.00
Багаж, техник, хэрэгсэл	0.60	0.02	0.58	0.01
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.84	0.84	0.00	0.40
Урсгал засвар	0.70	1.26	-0.56	0.60
Томилолт, зочны зардал	0.60	0.13	0.47	0.06
Дотоод албан томилолт	0.60	0.13	0.47	0.06
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7.80	7.73	0.06	3.65
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6.94	6.92	0.02	3.27
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.25	0.25	0.00	0.12
Даатгалын үйлчилгээ	0.21	0.21	0.00	0.10
Тээврийн хэрэгслийн татвар	0.15	0.13	0.02	0.06
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.05	0.09	-0.04	0.04
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.20	0.13	0.07	0.06
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.90	0.90	0.00	0.42
Бусад урсгал шилжүүлэг	0.90	0.90	0.00	0.42
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.90	0.90	0.00	0.42
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	213.50	213.50	0.00	100
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	213.50	213.50	0.00	100
Орон нутгийн төсвөөс	213.50	213.50	0.00	100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	0.00	
Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	
Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.00	
Үйлчлэх ажилтан	17.00	17.00	0.00	

Нийт зардлын гүйцэтгэлийн 78.97 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 8.65 хувийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 2.91 хувийг тогтмол зардал эзэлж байна.

Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журмаар зөвшөөрөгдсөн зардлын зүйл хооронд гүйлгэн зарцуулж хэтрэлт үүссэн боловч бүлгийн дүнгээр төсөвт зардлыг хэтрүүлээгүй, зардлын бүлэг хооронд мөн зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулаагүй байна.

Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газрын даргын 2017.12.19-ний өдрийн 23-р тушаалаар байгууллагын дотоод журмын 13.1.2, 13.2 дахь заалтыг үндэслэн жилийн ажлын үр дүнгийн урамшуулал болох 13 дахь сарын цалинг үндсэн цалингийн 30-55 хувиар тооцож нийт 3.4 сая төгрөгийг бодож олгосон байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", төрийн албаны тухай хуулийн 28.2.4-д "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ", 28.13-д "Энэ зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь төрийн албан хаагчийн цалин хөлсний 40 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Мөн 2017 онд нийт 19.5 сая төгрөгийн шатахуун, 27.8 сая төгрөгийн гацуур мод, паркийн сарнайг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Энэ нь хэмнэгдсэн зардлыг хууль, тогтоомж зөрчин үндэслэлгүйгээр зарцуулсан, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчим алдагдсан үйл ажиллагаа болжээ.

2.3 Шатахууны төлбөрт оны эцэст илүү төлбөр шилжүүлснээр авлага үүсгэсэн, төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар нь 2017 оны эхэнд нийт 2.88 сая төгрөгийн авлагатай байсан бол оны эцэст 1.91 төгрөгийн авлагатай ажилласан байна. Эдгээр нь шатахууны зардлын илүү төлөлт, ХХОАТ-ын авлагаас бүрдэж байна.

Шатахууны төлбөрт 2017.12.21-нд 4.4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлж 1.9 сая төгрөгийн авлага үүссэн байна. Өмнөх онд мөн шатахууны төлбөрийг илүү шилжүүлж 2.8 сая төгрөгийн авлага үүсгэж байжээ.

Мөн ХХОАТ-ын авлага 84.0 мянган төгрөгөөс оны эцэст 17.1 мянган төгрөг болсон бол тогтмол зардалтай холбоотойгоор 272.8 мянган төгрөгийн өглөг тайлагнасан байна.

Авлага, өр төлбөрийн хүснэгт /мянган.төгтөг/

Авлагын талаар /2017 он /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Тайлбар
Шатахууны зардалтай холбоотой авлага	2,800.00	1,899.78	
Бусад зардлын тооцооны авлага	84.06	17.13	Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого /Суутган-1/
Дүн	2,884.06	1,916.91	
Өглөгийн талаар / 2017 он /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Тайлбар
Түлш халаалтын тооцоо		263.68	
Цэвэр, бохир усны тооцоо		9.11	
Бусад өглөг		767.00	Б.Анхбаяр -
Дүн	0	1,039.79	

Орхон аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11-р сарын 04-ны өдрийн №165 магадлалаар өмнө нь даргаар ажиллаж байсан Б.Анхбаярт 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний ажлаас халагдсаны тэтгэмж 950.0 мянган төгрөг олгохоос Санхүүгийн хяналт, аудитын албанаас Б.Анхбаярт тавигдсан актын төлбөрийг суутгаж үлдсэн 767.0 мянган төгрөгийг 2018 онд барагдуулахаар өр төлбөрөөр бүртгэсэн байна.

Шатахууны төлбөрийг он дамнан илүү шилжүүлж авлага үүсгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, төсвийг авлага үүсгэх замаар мөн хуулийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасныг зөрчин хоёр төсвийн жил дамжуулан зарцуулсан үйл ажиллагаа гэж үзэхээр байна.

Тогтмол зардлын өр төлбөр үүссэн, 2017 онд тус зардлын төсөв буурч батлагдсан байтал дээд шатны төсвийн захирагчид хандаж батлагдсан төсөвт зохицуулалт хийх, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт гаргаж байгаагүй байна.

Тогтмол зардлын батлагдсан төсөв болон төсвийн төсөл. /мян.төг/

Үзүүлэлт	Он			
	2016		2017	
	Төсөвлөсөн	Батлагдсан	Төсөвлөсөн	Батлагдсан
Түлш халаалт	2,497.50	2,497.50	2,497.50	2,006.15
Цэвэр бохир ус	2,256.80	1,560.00	2,256.80	1,107.60
Гэрэл цахилгаан	840.00	600.00	840.00	600.00
Дүн	5,594.30	4,657.50	5,594.30	3,713.75
Батлагдсан нийт төсөв		213,500.00		213,500.00

Дээрхээс тус газар нь зориудаар авлага үүсгэдэг, ХХОАТ-ын илүү төлөлтийг бүрэн хасч суутгасан татварыг шилжүүлээгүй, тогтмол зардлын өр төлбөрийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй нь харагдаж байна.

Бүлэг 3: Үндсэн хөрөнгөд тавих хяналт хангалтгүйгээс хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй, үр дүн гараагүй байна.

3.1 Тус байгууллага нь 77.3 сая төгрөгийн ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн нь холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ-аар 2017 оны хөрөнгө оруулалтын жагсаалтыг 4 удаа тодотгож баталсан бөгөөд 2017оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор:

- Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжид ургамлан хашлага, амьд хашаа хийх төсөл арга хэмжээнд 171.9 сая төгрөг
- Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд 57.4 сая төгрөг
- Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээнд 19.9 сая төгрөг тус тус батлагдсан байна.

Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх төсөл арга хэмжээ 57.4 сая төгрөг, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ 19.9 сая төгрөг нийт 2 төсөл арга хэмжээний 77.3 сая төгрөгийн төсвийн саналыг Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар өөрсдөө хүргүүлж, гүйцэтгэгчээр нь өөрсдөө гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжид ургамлан хашлага, амьд хашаа хийх төсөл арга хэмжээ-ний худалдан авах ажиллагааг Орон нутгийн өмчийн газар зохион байгуулж 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр Өндөр хүлэмж ЗБН-нд гэрээ байгуулах эрх олгосны дагуу 169.8 сая төгрөгийн өртөгтэй 60633 ширхэг шар хуайс, 2.1 сая төгрөгийн өртөгтэй 738 ширхэг хайлаас, нийт 61371 ширхэг ургамлыг 171.9 сая төгрөгийн өртгөөр худалдан авч Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт нийлүүлснийг тус байгууллага 19 байршилд шилжүүлэн суулгаж, Байгаль орчны газраас арчилгааны зардалд 20.0 сая төгрөгийг авч зарцуулсан байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар 2017 оны 03 дугаар сарын 6-ны өдрийн 21 тоот албан бичгээр Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн бөгөөд худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар 2017 оны 03 дугаар сарын 10-ны 3 дугаар сарын 20-ны өдөр хүртэл зохион байгуулж тендерт шаардлага хангасан материал ирээгүй тул захиалагчид шууд гэрээ байгуулах эрх олгосон байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 23 тоот аймгийн ЗДТГ-т явуулсан албан бичигт дурдсан гэрээ байгуулах хүсэлтийн дагуу 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх ОР-110/2017 тоот гэрээний нийлүүлэгчээр захиалагч Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газартай гэрээ байгуулсан байна.

Гэрээний дагуу Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар 2017 оны 04 дүгээр сарын 18-ны бараа хүлээн авсан комиссын ОР-05/2017 тоот акт үйлдэж / нийлүүлсэн, хүлээн авсан 1 байгууллага/ гарын үсэг зурж баталгаажуулан, санхүүжилтээ бүрэн авсан байна.

Дээрхээс үзэхэд ашиг олох зорилгогүй, орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагад хэт давуу байдал олгож тоног төхөөрөмж нийлүүлэх техникийн тодорхойлолтыг өөрсдөө гаргаж, өөрсдөө нийлүүлэгч болж гэрээ байгуулж, ашиглагч болж өөрийн нийлүүлсэн тоног төхөөрөмжөө хүлээн авч байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-н 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т “ Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 20.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно” гэсэн зүйл заалтуудыг зөрчсөн байна.

Иймд цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжид хөрөнгө зарцуулахдаа бизнес эрхлэгчдийг дэмжин, өрсөлдөөний тэгш байдлыг хангаж, ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний дагуу нийлүүлэгдсэн 19.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг үзэхэд 0.7 сая төгрөгийн агааржуулалтын сэнсийг ашиглаж үзээгүй, суурилуулаагүй байгаа нь үр дүн тодорхойгүй хөрөнгө оруулалт болсон байна.



Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор 57.4 сая төгрөг батлагдсан бөгөөд төсөвт суулгахдаа шууд зардлын дүн болох 52.2 сая төгрөг нэмэгдсэн өртгийн албан татвар 5.2 сая төгрөг, нийт 57.4 сая төгрөг баталсан байна.

Харин Орон нутгийн өмчийн газар шууд зардлаар баталсан учраас жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаагүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй бөгөөд захиалагч Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газраар гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулан он дамжин хэрэгжиж 2017 оны гүйцэтгэлээр 51.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна .

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.20-д “ТБОНӨХБАҮХАТХ тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж буй орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллага байтал хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг 57.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр аймгийн засаг даргатай БЗА-216/17 тоот гэрээг 2017 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээний дүн 57.4 сая төгрөг нь шууд материалын зардал бөгөөд түүнд нэмэгдсэн өртгийн албан татварын 5.2 сая төгрөгийг оруулж тооцсон нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйл Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх 13.6.12-т “ төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ; Үүнд Засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна” гэсэн заалтыг зөрчсөн байх тул аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэст НӨАТ-ын дүнг хасч санхүүжүүлэх тухай албан шаардлага хүргүүлсэн.

Тус ажил нь он дамжин гүйцэтгэж 2018 оны 06 сард дуусаж улсын комисст хүлээлгэн өгөхөөр хүсэлтээ өгсөн бөгөөд гүйцэтгэлийг үзэхэд 4.48 сая төгрөгийн өртөг бүхий 204 ширхэг паркийн сарнайг нэг нүхэнд 5-ийг нийт 41 нүхэнд суулгасан боловч ургалт хангалтгүй зарим

сарнай унасан сул байгаа зэрэг нь арчилгаа тордолгоо хангалтгүйгээс хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг хангалтгүй болгосон байна.



Иймд хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын ашиглалт хамгаалалт, арчилгааг тухай бүр чанартай хийж гүйцэтгэн ургамлын ургалтыг сайжруулахад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2 Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь үйл ажиллагаа явуулаад удаагүй боловч орон нутгийн санхүүжилтээр авсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй, бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт 2017 оны байдлаар 76.7 сая төгрөгийн 2 барилга байгууламж, 68.9 сая төгрөгийг 4 тээврийн хэрэгсэл, 30.8 сая төгрөгийн 36 төрлийн тоног төхөөрөмж, 8.03 сая төгрөгийн 32 ширхэг тавилга эд хогшил, 380.6 сая төгрөгийн 87600 ширхэг ургамал бут сөөг, нийт 488.33 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Харин байгууллагад нэн шаардлагатай усалгааны автомашин байхгүйн улмаас Хот тохижуулах газрын ЗИЛ 130 автомашиныг тухайн оны 4 дүгээр сараас 11 сар дуустал хугацаанд шатахуун хийж ашигладаг байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын шатахуун зарцуулалтын анхан шатны баримтыг үзэхэд:

Үндсэн данснаас 3.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 15.85 сая төгрөг нийт 19.57 сая төгрөгийн шатахууныг 2017 онд зарцуулахдаа хяналтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан “ Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-д заасны дагуу шаардах хуудсыг НХМаягт БМ-6, жолоочийн тооцооны хуудсыг НХМАягт ТМ-4-ын дагуу хөтлөөгүй, шаардах хуудас хүссэн болон бараа материал хүлээж авсан ажилтны гарын үсэг огт зурагдаагүй, зарцуулалтын тооцоо бодуулсан жолоочийн гарын үсэг, тооцоог хянаж шалгаж бодсон эсэх нь тодорхойгүй, нярав болон нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажаагүй, шатахуун зарцуулалтын тооцоог үндсэн чиг үүргийнхээ дагуу нярав болон нягтлан бодогч нар хянаж тооцоог бодох ёстой байтал ахлах мэргэжилтэн хянаж гарын үсэг зурсан нь байгууллагын удирдлага дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ.

2016 оны санхүүгийн аудитаар 454 кг 11.35 сая төгрөгийн үр складад тусгай зориулалтын материалын үлдэгдэл хэвээр хадгалагдаж байгаа нь тухайн үрийн чанар байдал алдагдаж,

шаардлага хангахгүй болох эрсдлийг агуулж байна гэж үзэн менежментийн захидалд тусгаж зөвлөмж хүргүүлсэн байтал 2017 онд нэмэлт санхүүжилтийн данснаас 5.9 сая төгрөгөөр 237 кг зүлэгний үрийг нэмж авсан байна.

Дээрх 691 кг зүлэгний үрийг тарьсан газруудаар ургасан байдлыг үзэхэд: 2017 онд 5.9 сая төгрөгөөр худалдан авсан зүлэгний үрийг 5 дугаар хороололд тарьсан бөгөөд ургалтын байдал хангалттай сайн байна.



Харин 2016 оноос хойш хадгалагдсан 11.35 сая төгрөгийн 454 кг зүлэгний үрийг 5675 м² талбайд тарьсан боловч ургалт хангалтгүй байгаа нь автозамын цэвэрлэгээ арчилгаанаас үүссэн шороо, цасыг бродурын хажуу ирмэг хэсэг рүү гаргаж зөөх, хүний хөлөөр ургаж буй зүлэг дарагдах, зүлэгний үрийн чанар байдал, байнгын арчилгаа тордолгоо, усалгаа хангалтгүй гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалсан байна.



Тухайн онд хийгдсэн дараах ажлуудын бүртгэлийн байдлыг үзэхэд: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжид ургамлан хашлага, амьд хашаа хийх төсөл арга хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтад 171.9 сая төгрөг батлагдсаны дагуу 169.8 сая төгрөгийн өртөгтэй 60633 ширхэг шар хуайс, 2.1 сая төгрөгийн өртөгтэй 738 ширхэг хайлаас нийт 61371 ширхэг ургамлыг 171.9 сая төгрөгийн өртгөөр Өндөр хүлэмж ЗБН-ээс худалдан авч Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар үндсэн хөрөнгийн ногоон байгууламжийн дансанд бүртгэсэн байна.

Хотын ногоон байгууламж нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд 57.4 сая төгрөгийн ажил он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд 2017 онд 51.7 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсныг бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансанд 49.7 сая төгрөг бүртгэж 2.0 сая төгрөгийн зарцуулалтыг бүртгээгүй байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын өвлийн нарлаг хүлэмжинд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээний 19.9 сая төгрөгөөс 3.23 сая төгрөг буюу 16.3% нь үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд, 16.67 сая төгрөг буюу 83.8% нь тусгай зориулалтын бараа материалд бүртгэж, 2017 оны эцэст 8.5 сая төгрөгийн үрсэлгээний бортого, үрсэлгээний хөвдөн хөрс, нүүрс, түлээ, цэцгийн үр зэргийг зарлагадсан байна.

Үүнээс үзэхэд нийт нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн 83.8% нь бараа материалын дансанд бүртгэгдэж, тайлант онд зарлагадсан нь Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэсэн зүйл заалтыг зөрчсөн байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь Хот тохижуулах газраас мод үржүүлгийн зориулалтаар 21465 м² талбайг балансаас балансад шилжүүлсэн авсан бөгөөд уг талбайг 2014 онд байгуулагдсанаасаа хойш зориулалтын дагуу огт ашиглаагүй нь аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 166 дугаар тогтоолоор баталсан байгууллагын дүрмийн 1.2-т “ хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, **үржүүлэх** нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх” гэсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна.

Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тус байгууллагад орон нутгаас 600 м² талбайд 2015 онд 43.1 сая төгрөгийн өртөг бүхий өвлийн хүлэмж, хүлэмжийн усалгаа болон халаалтын системд 20.0 сая төгрөг, нийт 63.1 сая төгрөг, 2016 онд хүлэмжний хажуу хэсэгт ажилчдын байрыг 33.6 сая төгрөгөөр барьж байгуулан ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

Гэтэл өвлийн нарлаг хүлэмжинд 2017 онд 19.9 сая төгрөгөөр 30.0 мянган цэцэг үрслүүлэн 7 байршилд, 2018 онд 15.0 сая төгрөгөөр 33.0 мянган цэцэг үрслүүлэн 9 байршилд суулгасанаас өөр ажил хийгдээгүй, тухайн жилийн 6 дугаар сарын 20-д хүртэл цэцгийг тарьж шилжүүлэн суулгаснаас хойш дараа жилийн үрсэлгээ хийх хүртэл хугацаанд хүлэмж ашиглагдахгүй байгаа нь 96.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын үр дүн, ашиглалт хангалтгүй гэж үзэхээр байна.

Мөн түүнчлэн 2014 онд орон нутгаас нийлүүлэгдсэн 12.9 сая төгрөгийн өртөг бүхий бага оврын трактор одоог хүртэл бичиг баримтгүй гэсэн шалтгаанаар хөрөнгийг ашиглахгүй, үр дүнгүй хадгалсаар байна.

Тухайн байгууллага нь хотын авто зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийг хариуцдаг бөгөөд 2017 оны байдлаар 380.6 сая төгрөгийн 22 нэр төрлийн 7625 ширхэг мод, 109130 ширхэг бут сөөг, 124.7 мянган м² зүлэг талбайтай бөгөөд энэ нь нийт хөрөнгийн 78 хувийг эзэлж байна.

Гэтэл байгууллагын даргын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 21 тоот тушаалаар баталсан тооллогын комиссын хийсэн тооллогоор нярвын тооллогын бүртгэлд тоолсон гэж комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан боловч 87600 ширхэг модноос хэд нь ургасан, хэд нь үхсэн, хорогдол хэдэн хувьтай байгаа эсэх, алга болсон нь хэд гэх мэт мэдээлэл байхгүй нь хөрөнгийн ихэнхи хувийг эзэлдэг ногоон байгууламжийн бүртгэлээр тавих хяналт сул хангалтгүй байна.

Иймд жил бүр тооллого хийхдээ бүртгэлд байгаа ургамал, ногоон байгууламж хаана хаана байгаа, түүнийг хэрхэн тоолж хорогдол хичнээн байгаа талаар хяналт тавьж ажилласан тухай тодорхой тэмдэглэл үйлдэж баталгаажуулан, тооллогын баримтанд хавсаргаж байх шаардлагатай байна.

3.3 Шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ байршуулдаг боловч зарим мэдээллийг буруу, дутуу байршуулсан байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ил тод байдлын самбар ажиллуулж, мэдээллээ shilendans.gov.mn сайтад байршуулдаг бөгөөд байршуулсан мэдээллээс үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл 6.1.6-д “ төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” байршуулах ёстой бөгөөд Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь төсвийн хэтрэлт хэмнэлтийг тоон үзүүлэлтээр оруулсан боловч түүний шалтгаан тайлбарыг огт бичээгүй байна.

Мөн хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” зүйл заалтын дагуу 24 ажил гүйлгээний 299.94 сая төгрөгийн мэдээлэл оруулахаас 22 ажил гүйлгээний 279.46 сая төгрөгийн ажил гүйлгээг мэдээлж 2 ажил гүйлгээний 20.48 сая төгрөгийн орлогын гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Хуулийн 6.4.4-т “ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” зүйлд заасны дагуу мэдээлэх ёстой боловч тус байгууллага нь тээвэр шатахуун 15.85 сая төгрөг, багаж техник хэрэгсэл 11.0 сая төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээ 69.43 сая төгрөгийг мэдээллийг бүрэн мэдээлээгүй, буруу мэдээлсэн байна.

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын дарга нь 2017 онд төсөв хөрөнгө зарцуулах, бүтэц орон тоотой холбоотой 27 тушаал шийдвэр гаргасан байтал тушаал бүртэй холбоотой ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаагүй, шилэн дансанд мэдээлээгүй нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-т “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэсэн зүйл заалтыг зөрчсөн байна.

Шилэн дансны хуулийн 6.4.8-д “ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасны дагуу Байгаль орчны газар болон орон нутгийн хөрөнгө оруулалтаас гэрээгээр гүйцэтгэхээр болсон 2 төсөл арга хэмжээний гэрээ, төсөв хөрөнгөтэй холбоотой 12 тушаал, нийт 15 гэрээ, тушаал шийдвэр мэдээлэхээс 2 гэрээ, 8 тушаал шийдвэрийг мэдээлж 5 тушаал шийдвэрийг дутуу мэдээлсэн байна.

Дээрхээс дүгнэхэд шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ цахим сайтад байршуулж байгаа боловч зарим мэдээллийг дутуу, буруу мэдээлсэн байна.

Тус байгууллагын удирдлагын бүтцэд дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч, нарийн бичиг гэсэн 4 ажилтан ажилладаг бөгөөд хяналт тавих бүтэц байхгүй байна.

Иймд шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулах зайлшгүй шаардлагатай мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж, тухай бүр оруулсан мэдээллийг үнэн эсэхийг хянаж байх шаардлагатай байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Дотоод хяналт алдагдсанаас хөрөнгийн ашиглалт хангалтгүй, төсвийн төсөөллийг зорилтот төвшинд арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар бодитой төлөвлөөгүй байна

Дээрх дүгнэлтэд үндэслэн аудитын явцад 194.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж аймгийн засаг даргад 1 зөвлөмж, аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газарт 77.3 сая төгрөгийн зөрчилд тус тус 1 зөвлөмж, аймгийн СТСХ-т 5.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт 19.57 сая төгрөгийн 1 албан шаардлага, 112.4 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Зөвлөмж:**Аймгийн засаг даргад:**

- Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг үзүүлэлт тус бүрээр бодитой дүгнэж байх

Аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газарт:

- Өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажилладаг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хэлбэрт шилжүүлэх боломжийг судлах
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжид хөрөнгө зарцуулахдаа өрсөлдөөний тэгш байдлыг хангаж, ТБОНӨХБАУХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллах

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт:

- Хөрөнгийн тооллого хийхдээ бүртгэлд байгаа ургамал, ногоон байгууламж хаана хаана байгаа, түүнийг хэрхэн тоолж хорогдол хичнээн байгаа талаар хяналт тавьж ажилласан тухай тодорхой тэмдэглэл үйлдэж баталгаажуулан тооллогын баримтанд хавсаргаж байх.
- Шилэн дансны тухай хуулийн дагуу зайлшгүй шаардлагатай мэдээллийг бүрэн мэдээлж, тухай бүр мэдээллийн үнэн зөв эсэхийг хянаж байх.
- Төсвийг бодитой төлөвлөх, төсвийн хэмнэлтийг илүү шилжүүлэх замаар авлага үүсгэж төсвийн жил дамнан зарцуулахгүй байх.
- Дотоод хяналтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа үр нөлөөтэй хэрэгжүүлэх.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Г.ОРГИЛМӨРӨН
Т.БОЛОРМАА
Б.БУЯН-УНДРАХ

ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН
ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮН ”

ӨРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Дотоод хяналт алдагдсанаас хөрөнгийн ашиглалт хангалтгүй, төсвийн төсөөллийг зорилтот төвшинд арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар бодитой төлөвлөөгүй байна

Дээрх дүгнэлтэд үндэслэн аудитын явцад 194.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж засаг даргад 1 зөвлөмж, аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газарт 77.3 сая төгрөгийн зөрчилд тус тус 1 зөвлөмж, аймгийн СТСХ-т 5.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт 19.57 сая төгрөгийн 1 албан шаардлага, 112.4 төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Зөвлөмж:

Засаг даргад:

- Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг үзүүлэлт тус бүрээр бодитой дүгнэж байх


ЗДТГ, Орон нутгийн өмчийн газарт:

- Өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажилладаг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хэлбэрт шилжүүлэх боломжийг судлах
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжид хөрөнгө зарцуулахдаа өрсөлдөөний тэгш байдлыг хангаж, ТБОНӨХБАУХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллах

Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт:

- Хөрөнгийн тооллого хийхдээ бүртгэлд байгаа ургамал, ногоон байгууламж хаана хаана байгаа, түүнийг хэрхэн тоолж хорогдол хичнээн байгаа талаар хяналт тавьж ажилласан тухай тодорхой тэмдэглэл үйлдэж баталгаажуулан тооллогын баримтанд хавсаргаж байх.
- Шилэн дансны тухай хуулийн дагуу зайлшгүй шаардлагатай мэдээллийг бүрэн мэдээлж, тухай бүр мэдээллийн үнэн зөв эсэхийг хянаж байх.
- Төсвийг бодитой төлөвлөх, төсвийн хэмнэлтийг илүү шилжүүлэх замаар авлага үүсгэж төсвийн жил дамнан зарцуулахгүй байх.
- Дотоод хяналтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа үр нөлөөтэй хэрэгжүүлэх.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР  Г.ОРГИЛМӨРӨН
АУДИТОР  Т.БОЛОРМАА
АУДИТОР  Б.БУЯН-УНДРАХ


Хавсралт № 01

“Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/ сая.төгрөгөөр/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
07/75	Шатахууныг захиран зарцуулахдаа хяналтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй.	ЦНБГ	Дарга, нягтлан бодогч	Х.Оюун-Эрдэнэ, Б.Наранцэцэг		19.57
08/76	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж буй орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллага байтал хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг 57.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр аймгийн засаг даргатай БЗА-216/17 тоот гэрээг 2017 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээний дүн 57.4 сая төгрөг нь шууд материалын зардал бөгөөд түүнд нэмэгдсэн өртгийн албан татварын 5.2 сая төгрөгийг оруулж тооцсон.	СТСХ	Дарга, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	Н.Бямбацэцэг М.Алтангэрэл		5.2
	Нийт дүн					24.77

Холбогдох байгууллагын санал:



ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ - НОГООН БАЙГУУЛАМЖ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Монгол улс, Орхон аймаг: Баян-Өндөр сум,
Зас бөг. Засагтаны 02 байр
УБД-2014001010, Утас: (075) 73300887
E-mail: info_2014@yuhon.gov.mn

2018.07.25 № 67

талай _____ -ийг № _____-г

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас өгсөн 2017 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн аудитын төсөлтэй танилцлаа.
Цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн анхаарч ажиллах болно.


ДАРГА *[Signature]* Х.ОЮУН-ЭРДЭНЭ
[Signature]
2018.07.25
[Signature]

D:\2018\VA5 blank 67

